**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2 төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**АУДИТЫН КОД:** СНАГ-2025/057/НА-СТА-ТХН

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663, Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512, Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Аудитор: Ж.Мөнхбилгүүн<br>Утас: 261628, Цахим хаяг: munkhbilguunj@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Бэйкер Тилли Далайван Аудит ХХК<br>Ерөнхий захирал: Ц.Жигдэн<br>Утас: 7000-5401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.08 № 07/1406
танай ____________-ны №______________-т

БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР-2 ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Б.БАЯН-АМГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2 төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн нийт санхүүжилт 125,000.0 мянган ам доллар бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар 120,527.8 мянган ам доллар буюу 259,116,887.9 мянган төгрөгийн зээлийг ашиглаж 96.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн сум чиглэлийн 38.5 км авто зам барих ажлын санхүүжилтийн 2,012.6 мянган ам.долларын үлдэгдлийг төсөл хаагдсан тул “Бүс нутгийн авто замын хөгжил, засвар арчлалтын төсөл”-д шилжүүлсэн байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 2014 оны 3129-MOH дугаартай зээлийн гэрээний дагуу хэрэгжсэн Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2 төсөл нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон ба санхүүгийн үйл ажиллагааг хаах хугацааг нийт 5 удаа сунгаж 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болгосон байна.

Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2 төслийн зээлийн санхүүжилтийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хаасан тул төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны үйл ажиллагааны 128,342.2 мянган төгрөгийн зардлыг Сангийн сайдын төсвийн багцаас санхүүжүүлсэн байна.

**Бусад асуудал**

Тайлант онд Төслийн Удирдах Хороо төслийн үйл ажиллагааг хаахтай холбоотой 12 ажлын гүйцэтгэхээр төлөвлөгөө баталсныг бүрэн хэрэгжүүлсэн, гүйцэтгэл 100 хувь гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9023030583

Z:\Yawsan_Bichig\2025\0409 SNAG-3.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **253,055,443,212.98** | **17,078,125,209.04** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **382,811,610.40** | **467,350,021.87** |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 382,811,610.40 | 467,350,021.87 |
| **3121** | **Төгрөг** | **30,747,500.83** | **199,211.51** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 30,747,500.83 | 199,211.51 |
| **3122** | **Гадаад валют** | **352,064,109.57** | **467,150,810.36** |
| 31224 | Төрийн сангийн харилцах | 352,064,109.57 | 467,150,810.36 |
| **335** | **БУСАД АВЛАГА** | **751,088,565.50** | **-** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 751,088,565.50 | - |
| **36** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **251,921,543,037.08** | **16,610,775,187.17** |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө | 251,921,543,037.08 | 16,610,775,187.17 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **-** | **-** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **-** | **-** |
| **392** | **Биет хөрөнгө** | **-** | **-** |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 10,439,740.00 | - |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (10,439,740.00) | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=2+1** | **253,055,443,212.98** | **17,078,125,209.04** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **16,987,621,938.01** | **610,708,792.59** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **16,987,621,938.01** | **610,708,792.59** |
| **413** | **Өглөг** | **16,987,621,938.01** | **610,708,792.59** |
| **4136** | **Бусад өглөг** | **16,987,621,938.01** | **610,708,792.59** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 16,987,621,938.01 | 610,708,792.59 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | - |
| 41363 | Татварын өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **236,067,821,274.97** | **16,467,416,416.45** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **236,067,821,274.97** | **16,467,416,416.45** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **236,067,821,274.97** | **16,467,416,416.45** |
| 51210 | Өмнөх хугацаат үр дүн | 219,641,218,348.11 | 242,258,607,919.98 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 16,426,602,926.86 | (225,791,191,503.53) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=5+4** | **253,055,443,212.98** | **17,078,125,209.04** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)** | **16,485,756,218.42** | **24,959,990,157.03** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,485,756,218.42** | **24,831,647,907.03** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **16,485,756,218.42** | **24,831,647,907.03** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 16,485,756,218.42 | 24,831,647,907.03 |
| 1200044 | Гадаад эх үүсвэрээс санхүүжих | 16,485,756,218.42 | 22,744,728,761.29 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 2,086,919,145.74 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **128,342,250.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | 128,342,250.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 128,342,250.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (2)** | **86,472.75** | **128,426,642.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **86,472.75** | **128,426,642.25** |
| 210101 | Үндсэн цалин | - | 97,970,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 12,246,250.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 16,876,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 50,000.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | - | 1,200,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 86,472.75 | 84,392.25 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **16,485,669,745.67** | **24,831,563,514.78** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **10,920,282.66** |
| 450001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 10,920,282.66 |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)** | **59,066,818.81** | **250,633,675,300.97** |
| 550001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 59,066,818.81 | - |
| 550002 | Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал | - | 250,633,675,300.97 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4)-(5)** | **(59,066,818.81)** | **(250,622,755,018.31)** |
| **7** | **НИЙТ ҮР ДҮН (7)=(3)+(6)** | **16,426,602,926.86** | **(225,791,191,503.53)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **624,367,567.34** | **2,154,199,985.03** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **624,367,567.34** | **2,154,199,985.03** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **624,367,567.34** | **2,154,199,985.03** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **624,367,567.34** | **2,154,199,985.03** |
| 1200042 | Улсын төсвөөс санхүүжих | - | 128,492,300.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 624,367,567.34 | 2,025,707,685.03 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **488,710,961.48** | **333,909,264.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **488,710,961.48** | **333,909,264.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **488,710,961.48** | **333,759,214.00** |
| 210101 | Үндсэн цалин | 208,992,590.00 | 97,970,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,210,470.00 | 12,246,250.00 |
| 210304 | Байрны түрээс | 66,960,000.00 | 16,876,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,950,000.00 | 50,000.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 2,646,000.00 | 1,200,000.00 |
| 210404 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 550,000.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 338,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,431,050.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 169,632,851.48 | 205,416,964.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **150,050.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 150,050.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **135,656,605.86** | **1,820,290,721.03** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **1,740,695,246.07** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **1,740,695,246.07** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **1,740,695,246.07** |
| 220001 | Барилга байгууламж | - | 1,740,695,246.07 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(1,740,695,246.07)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(3,123,669.98)** | **4,942,936.51** |
| **14** | **Бусад эх үүсвэр** | **3,123,669.98** | **4,942,936.51** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 4,942,936.51 |
| 145002 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 3,123,669.98 | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **132,532,935.88** | **84,538,411.47** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **250,278,674.52** | **382,811,610.40** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **382,811,610.40** | **467,350,021.87** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **219,641,218,348.11** | **219,641,218,348.11** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - | - |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **219,641,218,348.11** | **219,641,218,348.11** |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | - | - |
| 5 | Тайлант үеийн үр дүн | | 16,426,602,926.86 | 16,426,602,926.86 |
| **6** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **236,067,821,274.97** | **236,067,821,274.97** |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | 6,190,786,645.01 | 6,190,786,645.01 |
| **8** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **242,258,607,919.98** | **242,258,607,919.98** |
| 9 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | - | - |
| 10 | Тайлант үеийн үр дүн | | (225,791,191,503.53) | (225,791,191,503.53) |
| **11** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **16,467,416,416.45** | **16,467,416,416.45** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **24,172,792,300.00** | **22,793,391,144.08** | **1,379,401,155.92** | **94.3** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,284,792,300.00** | **1,282,534,350.55** | **2,257,949.45** | **99.8** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,284,792,300.00** | **1,282,534,350.55** | **2,257,949.45** | **99.8** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **97,970,000.00** | **97,970,000.00** | **-** | **100.0** |
| Үндсэн цалин | 97,970,000.00 | 97,970,000.00 | - | **100.0** |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **12,246,500.00** | **12,246,250.00** | **250.00** | **100.0** |
| Тэтгэврийн даатгал | 12,246,500.00 | 12,246,250.00 | 250.00 | **100.0** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **16,876,000.00** | **16,876,000.00** | **-** | **100.0** |
| Байрны түрээс | 16,876,000.00 | 16,876,000.00 | - | **100.0** |
| **Хангамж, бараа материалын зардал** | **1,399,800.00** | **1,250,000.00** | **149,800.00** | **89.3** |
| Бичиг хэрэг | 199,800.00 | 50,000.00 | 149,800.00 | 25.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100.0 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,156,300,000.00** | **1,154,192,100.55** | **2,107,899.45** | **99.8** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,156,300,000.00 | 1,154,192,100.55 | 2,107,899.45 | 99.8 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **22,888,000,000.00** | **21,510,856,793.53** | **1,377,143,206.47** | **94.0** |
| Барилга байгууламж | 22,888,000,000.00 | 21,510,856,793.53 | 1,377,143,206.47 | 94.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **24,172,792,300.00** | **22,873,071,011.29** | **1,299,721,288.71** | **94.6** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **128,492,300.00** | **128,342,250.00** | **150,050.00** | **99.9** |
| Улсын төсвөөс санхүүжих | 128,492,300.00 | 128,342,250.00 | 150,050.00 | 99.9 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **24,044,300,000.00** | **22,744,728,761.29** | **1,299,521,238.71** | **94.6** |
| Гадаад эх үүсвэрээс санхүүжих | 24,044,300,000.00 | 22,744,728,761.29 | 1,299,521,238.71 | 94.6 |
| **Төсвийн тохируулга** | | **4,858,544.26** | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **382,811,610.40** | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **467,350,021.87** | | |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **4** | **3** | **-1** | **75.0** |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 3 | 2 | -1 | 66.7 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 259,710,610.1 мянган төгрөгийн 9 алдааг залруулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024.12.30-ны өдрийн тогтоолоор 12 нэр төрлийн 250,633,675.3 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллага болох Зам тээврийн яам, Зам тээврийн хөгжлийн газар, Ховд АЗЗА ТӨҮГ зэрэг байгууллагын хөрөнгөд шилжүүлэх тогтоол гарч, шилжүүлсэн боловч төслийн бүртгэлээс хасагдаагүй байна. | 1 | 250,633,675.3 | 1 | 250,633,675.3 | | | 1 | 250,633,675.3 | | | | |
| 2 | Өмнөх онуудын Засгийн газрын мөнгөн бус оролцоог тооцон бүртгээгүй байна. | 1 | 6,571,792.2 | 1 | 6,571,792.2 | | | 1 | 6,571,792.2 | | | | |
| 3 | Тайлант хугацааны нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийн бусад орлогыг дутуу бүртгэсэн. | 1 | 1,774,755.5 | 1 | 1,774,755.5 | | | 1 | 1,774,755.5 | | | | |
| 4 | Төсөл хаагдаж байгаа тул төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлыг өмнөх хугацааны хуримтлагдсан үр дүн руу хаах бичилтийг хийгээгүй байна. | 1 | 381,005.6 | 1 | 381,005.6 | | | 1 | 381,005.6 | | | | |
| 5 | Тайлант хугацаанд импортоор оруулсан тоног төхөөрөмжүүдийн гааль болон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийг бусад орлогоор бүртгэсэн боловч тухайн тоног төхөөрөмжийн өртөг буюу бусад эргэлтийн хөрөнгийн дансанд тусгаагүй байна. | 1 | 312,163.7 | | | 1 | 312,163.7 | 1 | 312,163.7 | | | | |
| 6 | Тайлант хугацааны эцэст гадаад валютын ханшны олз, гарзын дансны ажил гүйлгээний тооцооллыг зөрүүтэй дүнгээр бүртгэсэн. | 1 | 22,299.6 | | | 1 | 22,299.6 | 1 | 22,299.6 | | | | |
| 7 | Гадаад валютаарх барьцааны өр төлбөрийн үлдэгдлийг Монгол банкны хаалтын ханшаар тэгшитгэх үед болон үлдэгдлийг төлөх үед | 1 | 14,708.2 | | | 1 | 14,708.2 | 1 | 14,708.2 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үүссэн валютын ханшийн олз, гарзыг зөрүүтэй дүнгээр бүртгэсэн. | | | | | | | | | | | | |
| 8 | Мөнгөн гүйлгээний тайланд гадаад валютын ханшийн зөрүүний олзыг дутуу тайлагнасан. | 1 | 125.6 | 1 | 125.6 | | | 1 | 125.6 | | | | |
| 9 | Азийн хөгжлийн банкнаас хийгдсэн шууд төлбөрийн дундын дамжуулагч банкны 25 ам долларын шимтгэлийг санхүүгийн байдлын болон үр дүнгийн тайланд давхар тайлагнасан. | 1 | 84.4 | | | 1 | 84.4 | 1 | 84.4 | | | | |
| | **Дүн** | **9** | **259,710,610.1** | **5** | **259,361,354.2** | **4** | **349,255.9** | **9** | **259,710,610.1** | | | | |

**3.2** Аудитаар нийт 7,952,063.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн төслийн санхүүжилтээр худалдан авсан техник хэрэгсэл, хүнд механизм, замын үзлэгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэх албан бичгийг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй тул төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүртгэлээс хасаагүй байна. | 1 | 7,952,063.8 | | | | | 1 | 7,952,063.8 | | | | |
| | **Дүн** | **1** | **7,952,063.8** | | | | | **1** | **7,952,063.8** | | | | |